

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

НЭГ. ЗОРИЛГО

Энэхүү хяналт-шинжилгээний зорилго нь Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, дэмжлэг үзүүлэх, сайжруулах, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг баримтлав.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ журмын 2.4-д зааснаар арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг “Бүрэн хангалттай” /85-100 хувь/, “Хангалттай” /70-85 хувь/, “Хангалтгүй” /70-аас доош хувь/ гэсэн түвшингээр үнэлэв. Хэрэгжих хугацаа нь болоогүй (ХБ) арга хэмжээг дундаж үнэлгээнд хамруулсангүй.

ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 стратегийн зорилго, 33 гүйцэтгэлийн зорилт, 105 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үнэлгээг дор харуулав. /Дэлгэрэнгүй гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дараах хүснэгтээр харуулав/

№	Гүйцэтгэлийн зорилт	Арга хэмжээ	Биелэлтийн хувь			Хугацаа болоогүй арга хэмжээний тоо	Дундаж үнэлгээ %
			Бүрэн хангалттай 85-100	Хангалттай 70-85	Хангалтгүй 70-0		
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 1. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН БОДИТ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛНЭ.							
1	1.1.1. Хууль тогтоомж, бодлого, шийдвэр, журам, стандартыг боловсруулах, шинэчлэх, санал хүргүүлэх	6	4	-	-	2	100
2	1.1.2. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх	3	2	1	-	-	93.3
3	1.2.1. Олон улсын үнэлгээний цогц систем (DME)-ийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах	2	-	-	-	2	ХБ
4	1.2.2. Үндэсний болон салбарын бодлогод үнэлгээ хийх	2	-	-	-	2	ХБ
5	1.2.3. Хөгжлийн бодлогын хэрэгжилт, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тодорхойлж танилцуулах	10	6	-	1	3	94.3
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 2. ХУУЛЬ ЁСЫГ САХИУЛЖ, ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГЫГ САЙЖРУУЛНА.							
6	2.1.1. Засгийн газрын хяналт шалгалтын үйл ажиллагааг хууль, журамд нийцүүлэн хийж, үр дүнг тайлагнах	4	4	-	-	-	100

№	Гүйцэтгэлийн зорилт	Арга хэмжээ	Биелэлтийн хувь			Хугацаа болоогүй арга хэмжээний тоо	Дундаж үнэлгээ /%/
			Бүрэн хангалттай 85-100	Хангалттай 70-85	Хангалтгүй 70-0		
7	2.1.3. Байгууллагын үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд гарсан зөрчил илрүүлэлтийг сайжруулах	3	2	1	-	-	93.3
8	2.2.1. Иргэд, олон нийтийн байгууллага, мэргэшсэн зөвлөхүүдтэй хамтран ажиллах	10	7	1	-	2	94.9
9	2.2.2. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн бодит үр дүнг нэмэгдүүлэх	5	4	-	-	1	100
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 3. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, БҮТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД ЗӨВЛӨН ЧИГЛҮҮЛНЭ.							
10	3.1.1. Төрийн байгууллагуудад процессын дахин инженерчлэл хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, бүтээмжийг сайжруулах	6	2	-	-	4	100
11	3.2.1. Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх	3	2	-	-	1	100
12	3.2.2. Эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн төрийн байгууллагуудын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх	1	1	-	-	-	100
13	3.2.3. Төрийн байгууллагуудад эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийг мөрдүүлэх	2	2	-	-	-	93.8
СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 4. ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛНЭ.							
14	4.1.1. Үйл ажиллагааг автоматжуулах, их өгөгдөл, хиймэл оюун ухааны ашиглалтыг нэмэгдүүлэхэд зөвлөмж, дэмжлэг үзүүлэх	3	2	-	-	1	100
15	4.1.2. Хяналт шалгалтын цахим мэдээллийн санг нэвтрүүлж, хөгжүүлэх	1	-	-	-	1	ХБ
16	4.1.3. Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн санг хөгжүүлэх	3	3	-	-	-	100
17	4.1.4. Эрсдэлийн удирдлагын мэдээллийн сан бий болгох, хөгжүүлэх	1	-	1	-	-	80
18	4.2.1. Албан хаагчдыг эрсдэлийн удирдлага, процессын дахин инженерчлэл, үр дүнд суурилсан арга зүйгээр мэргэшүүлэх	1	1	-	-	-	100
19	4.3.1. Байгууллагад эерэг, бүтээлч, ногоон дадал бүхий соёлыг төлөвшүүлэх	3	1	-	1	1	65
20	4.3.2. Албан хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг дээшлүүлэх	1	-	-	1	-	20
21	4.3.3. ISO9001:2015 чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлэх	1	-	-	-	1	ХБ
22	4.3.4. Байгууллагын гадаад, дотоод хамтын ажиллагааг урт болон дунд хугацааны зорилго, зорилттой уялдуулан өргөжүүлэх	2	1	-	-	1	100
23	4.3.5. Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн төлөвшүүлэх	1	1	-	-	-	100
24	4.3.6. Байгууллагын удирдлагын мэдээллийн системийн үр ашиг, аюулгүй байдал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах	2	2	-	-	-	100

№	Гүйцэтгэлийн зорилт	Арга хэмжээ	Биелэлтийн хувь			Хугацаа болоогүй арга хэмжээний тоо	Дундаж үнэлгээ %
			Бүрэн хангалттай 85-100	Хангалттай 70-85	Хангалтгүй 70-0		
5. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ							
25	5.1. Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлага, манлайллыг хэрэгжүүлэх	8	7	1	-	-	95.8
26	5.2. Байгууллагын өдөр тутмын хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, архив, албан хэргийг хөтлөх	4	3	-	1	-	85.5
27	5.3. Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, төсөв санхүүгийн удирдлага, дотоод хяналтыг хэрэгжүүлэх	3	2	-	1	-	83.3
28	5.4. Архив, албан хэргийг хөтлөх, дотоод үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих	4	4	-	-	-	100
29	5.5. Байгууллагын дотоод үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэх, хурал, уулзалтыг зохион байгуулалтаар хангах	2	-	-	1	1	57.2
6. КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХҮҮЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ							
30	6.1. Мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын бодлого, дүрэм, журам, төлөвлөлт, орчны аюулгүй байдал	4	1	-	2	1	33.3
31	6.2. Системийн аюулгүй байдлыг хангах	1	-	-	-	1	ХБ
32	6.3. Сүлжээний аюулгүй байдлыг хангах	2	2	-	-	-	100
33	6.4. Серверийн өрөөний аюулгүй байдлыг хангах	1	1	-	-	-	100
Нийт		105	67	5	8	25	91.4

ДӨРӨВ. ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ АРГА ХЭМЖЭЭ

Хэрэгжилт хангалтгүй (70-аас доош хувь) 8 арга хэмжээ байна. Үүнд:

Арга хэмжээ 1.2.3.8. Хангалтгүй үнэлэгдсэн яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд газар дээр нь хяналт хийж, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх /зорилтот түвшин: 5 байгууллага/

Биелэлт: Ерөнхий хянан шалгагчийн 2026 оны 10 дугаар удирдамжийн дагуу Хөвсгөл, Сүхбаатар аймгийн хөгжлийн бодлогын хэрэгжилтэд газар дээр нь хяналт хийж, зөвлөмж өгсөн. Орхон, Булган аймгийн албан хаагчдад арга зүйн зөвлөгөө өгсөн бөгөөд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийгдэж байна.

Хяналт-шинжилгээ: Үнэлгээ 60 хувь. Зорилтот түвшингээр 5 байгууллагад хяналт хийхээр төлөвлөснөөс 3 байгууллагад хийж гүйцэтгэсэн, хяналт шалгалтын ажил үргэлжилж байгаа бөгөөд эхний хагас жилийн төлөвлөгөөгөөр төлөвлөсөн зорилтот түвшинд хүрээгүй байна.

Арга хэмжээ 4.3.1.2. Ажлын байрны эмх цэгцийг сайжруулах “5S хөтөлбөр”, бүтээмжийг нэмэгдүүлэх “Сайн саналын хөтөлбөр”-ийн төсөл боловсруулах, эхлүүлэх /зорилтот түвшин: төлөвлөгөөний төсөл-1, сургалт-1/

Биелэлт: Ажлын байрны эмх цэгцийг сайжруулах 5S аргачлалын сургалтыг “Менежмент ба ур чадварын хүрээлэн” ТББ-тай хамтран байгууллагын нийт албан хаагчдад зохион байгуулсан.

Хяналт-шинжилгээ: Үнэлгээ 30 хувь. Хоёр шалгуур үзүүлэлтээс зөвхөн сургалтын арга хэмжээ хэрэгжсэн бөгөөд 5S болон "Сайн саналын хөтөлбөр"-ийн ажлын төлөвлөгөөний төсөл, зохион байгуулах ажлын хэсгийн тушаал боловсруулагдаагүй байна.

Арга хэмжээ 4.3.2.1. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах /зорилтот түвшин: төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувь/

Биелэлт: 2026 оны Нийгмийн баталгааны хөтөлбөрийг 7 зорилтын хүрээнд 16 арга хэмжээгээр төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд 11 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж, 14 албан хаагчид цалинтай чөлөө олгох зэрэг арга хэмжээ хэрэгжүүлж, эрүүл мэндийн үзлэгийн чиглэлээр гэрээ байгуулсан.

Хяналт-шинжилгээ: Үнэлгээ 20 хувь. Хөтөлбөрийн хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар зорилтот түвшнээс /90 хувь/ доогуур буюу 20 хувьд хүрсэн, төлөвлөсөн арга хэмжээг зорилтот түвшинтэй уялдуулан тайлагнаагүй байна.

Арга хэмжээ 5.2.4. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд Ёс зүйн хороо, дэд хороодтой хамтран ажиллах, үр дүнг тайлагнах /зорилтот түвшин: арга хэмжээ-4, сэтгэл ханамж-90 хувь/

Биелэлт: Авлигатай тэмцэх газартай хамтран мэргэжил арга зүйн зөвлөмжийг 68 албан хаагчид хүргэсэн, Ёс зүйн дэд хорооноос харилцаа хандлага, 5S сэдэвт сургалт зохион байгуулсан, QR код бүхий мэдээллийн постер боловсруулсан зэрэг нийт 4 арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Хяналт-шинжилгээ: Үнэлгээ 50 хувь. Төлөвлөсөн 4 арга хэмжээ хэрэгжсэн боловч нөлөөллийн үйл ажиллагааны талаарх албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааг хийгээгүй /0 хувь/ байна.

Арга хэмжээ 5.3.3. Өмч хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан хөрөнгийн тооллого хийж, үр дүнг санхүүгийн тайланд тусгах /зорилтот түвшин: бүртгэл-2/

Биелэлт: Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, байгууллагын хагас жилийн болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын нэгдсэн тооллогыг 6 дугаар сард хийж гүйцэтгэсэн.

Хяналт-шинжилгээ: Үнэлгээ 50 хувь. Зорилтот түвшний 2 тооллогоос 1 нь эхний хагас жилийн тооллого хийж дуусаагүй, гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр төлөвлөсөн зорилтот түвшний хэрэгжилт хангагдаагүй байна.

Арга хэмжээ 5.5.1. Цаг үеийн шинжтэй, шуурхай зохицуулалт шаардсан ажил, арга хэмжээг зохион байгуулах, бусад нэгжид дэмжлэг үзүүлэх /зорилтот түвшин: ажил, арга хэмжээ-21/

Биелэлт: "Чөлөөлье" санаачилгын хүрээнд цахим уулзалт, 11-11 төвөөр ирүүлсэн мэдээллийг шийдвэрлэх, "Төрийн бүтээмж-Эдийн засгийн өсөлт" өдөрлөг, "Тэрбум мод тарих" зэрэг нийт 12 ажил, арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн.

Хяналт-шинжилгээ: Үнэлгээ 57.2 хувь. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилтот түвшний 21 ажил, арга хэмжээнээс 12-ыг зохион байгуулсан нь эхний хагас жилийн тайлангын зорилтот түвшинд хүрээгүй.

Арга хэмжээ 6.1.1. Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам боловсруулж, батлуулах /зорилтот түвшин: батлуулсан журам-1/

Биелэлт: "Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам"-ын төсөл боловсруулсан.

Хяналт-шинжилгээ: Үнэлгээ 0 хувь. Журмын төсөл боловсруулагдсан хэдий ч батлагдаагүй тул зорилтот түвшинд хүрээгүй байна.

Арга хэмжээ 6.1.2. Кибер халдлагад өртсөн системийг нөхөн сэргээх төлөвлөгөө болон кибер аюулгүй байдлыг хангах стратеги төлөвлөгөөг боловсруулж батлах /зорилтот түвшин: батлуулсан төлөвлөгөө-1/

Биелэлт: Кибер аюулгүй байдлыг хангах стратеги төлөвлөгөөний төслийг байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж байна.

Хяналт-шинжилгээ: Үнэлгээ 0 хувь. Төлөвлөгөөний төсөл боловсруулагдаж байгаа боловч батлагдаагүй, эхний хагас жилийн зорилтот түвшинд хүрээгүй байна.

ТАВ. ДҮГНЭЛТ

Дотоод хяналт, аудитын газар нь чиг үүргийн дагуу Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ хийлээ.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг нийт 33 гүйцэтгэлийн зорилт, 105 арга хэмжээнд хуваан төлөвлөсөн байна. Үнэлгээний дүнгээр 105 арга хэмжээнээс "Бүрэн хангалттай"-67, "Хангалттай"-5, "Хангалтгүй"-8, "Хэрэгжих хугацаа болоогүй"-25 байна. Хэрэгжих хугацаа нь болсон 80 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээ 91.4 хувь буюу "Бүрэн хангалттай" түвшинд үнэлэгдлээ.

ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг сайжруулах зорилгоор дараах зөвлөмжийг газар, хэлтсийн дарга, албан хаагчдад хүргүүлж байна. Үүнд:

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 2025 оны "Журам батлах тухай" 43 дугаар тогтоол, 2020 оны 217 дугаар тушаалыг тус тус баримтлан хүрэх зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг хэрэгжих боломжтой тоон болон чанарын утгаар илэрхийлж дахин төлөвлөж, батлуулах;

2. Кибер аюулгүй байдлыг хангах дотоод журам (6.1.1), нөхөн сэргээх болон стратеги төлөвлөгөө (6.1.2) нь зөвхөн төсөл хэлбэрт байгаа тул эдгээрийг яаралтай батлуулж, хэрэгжилтийг хангах;

3. Албан хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөр (4.3.2), эерэг, бүтээлч соёл төлөвшүүлэх (4.3.1, 5S хөтөлбөр) арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаа тул 3-4 дүгээр улиралд эрчимжүүлж, төлөвлөсөн үр дүнд бүрэн хүргэх;

4. Нийт арга хэмжээний 25 буюу дөрөвний нэг орчим нь хэрэгжих хугацаа болоогүй (ялангуяа DME систем, цахим мэдээллийн сан, чанарын удирдлагын

тогтолцоо) тул эдгээрийн бэлтгэлийг хангаж, 3-4 улирлын тайлант хугацаанд төлөвлөсөн үр дүнд хүргэх;

5. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд ажлын явцыг тоочиж бичиж байгаа нь хангалтгүй бөгөөд цаашид тайланг тайлагнахдаа гарсан бодит үр дүн, өөрчлөлтийг тоон үзүүлэлтэд тулгуурлан, зорилтот түвшинд хүрсэн эсэхийг дүгнэж тайлагнах;


6. Гүйцэтгэлийн зорилтын дундаж үнэлгээ нь түүнд хамаарах арга хэмжээний үнэлгээтэй (жишээ нь 2.1.3, 2.2.2) зөрүүтэй байгаа тул зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт болон үнэлгээний аргачлалыг нэг мөр уялдуулах;

7. Засгийн газрын 2020 оны 217 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын 4.2 дахь хэсэг, Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 6.10-д заасны дагуу Тамгын газар нь байгууллагын гүйцэтгэлийн тайланг нэгтгэх бөгөөд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгж түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Иймд төлөвлөгөөний биелэлтийн хагас, бүтэн жилийн тайланг холбогдох газарт хугацаандаа хүргүүлж хэвших;

8. Хяналт-шинжилгээний үр дүнд үндэслэн өгсөн зөвлөмжийг удаа дараа биелүүлээгүй, шаардлагатай баримт бичиг, мэдээлэл, бусад холбогдох нотлох баримтыг заасан хугацаанд ирүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг удирдлагад уламжлах талаар холбогдох журамд заасан тул анхаарч ажиллах шаардлагатай байна.

Хянасан:


Дотоод хяналт, аудитын газрын
дарга



Р.Дэжид

Хяналт шинжилгээ хийсэн:

Дотоод хяналт, аудитын газрын
ахлах референт



У.Өлзийцэцэг